



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

┌ Мөнгөн урамшуулал олгох тухай ┐

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Төрийн албан хаагчид шагнал, урамшил олгох журмын 2.в дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ-ын засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн саналыг богино хугацаанд хангалттай сайн бэлтгэсэн ажилтан, албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосугай.

2. Урамшуулалд хамрагдах ажилтнуудын нэрс, мөнгөн урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Мөнгөн урамшуулалд зарцуулагдах 435,606 /дөрвөн зуун гучин таван мянга зургаан зуун зургаа/ төгрөгийг цалин хөлсний нэмэгдэл зардлаас бодож олгохыг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд даалгасугай.


ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600028

“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл,  
технологийн парк” орон нутгийн өмчит  
төсөвт үйлдвэрийн газрын даргын 2016 оны  
04 сарын 11 өдрийн 2/168 дугаар тушаалын хавсралт



МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН  
НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Овог нэр	Албан тушаал	Мөнгөн дүн /төгрөг/
1.	Ч.Батхишиг	Ус хангамж, ариутгах татуургын инженер	86, 451
2.	М.Жавхланчимэг	Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан эдийн засагч	117, 327
3.	С.Ариунбилэг	Үйл ажиллагааны төлөвлөлт хариуцсан эдийн засагч	96, 114
4.	Г.Пүрэвдорж	Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер	135, 714
		Нийт дүн	435, 606

--oOo--